

# Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГСА-2022/63/СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Чойр хот 2022 он	Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа Утас:70543156 Цахим хаяг: Saranmuyab@audit.gov.mn  Аудитын менежер: Г.Наранбаяр Утас:70543179 Цахим хаяг: Naranbayarg@audit.gov.mn  Ахлах аудитор: Ц.Батсайхан Утас: 70543179 Цахим хаяг: Batsaikhants@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
3. Аудитын тайлан.....	13
3.1 Ерөнхий зүйл.....	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	14
3.4 Материаллаг байдал .....	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	17
3.8 Аудитын гол асуудал .....	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	18
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	18
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	18
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
4. Аудитын илрүүлэлт .....	19
4.1 Залруулсан алдаа.....	19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	20

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ГСА	Говьсүмбэр аймаг
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг

Утас/Факс: 976-7054 3179

И-мэйл: govsumber@audit.gov.mn

**АЙМГИЙН "ГАЗРЫН ХАРИЛЦАА,  
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН  
ГАЗАР"-ЫН ТӨСВИЙН ЗАХИРАГЧ  
Б.ОТГОНЧИМЭГ ТАНАА**

2022.02.24 № 07

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу аймгийн "Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар"-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аймгийн "Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар"-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

4208020021

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.САРАНТУЯА



## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	66,416,272.08	91,120,933.20
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	65,592.00	0
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	65,592.00	0
31210	Төгрөг	65,592.00	0
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	65,592.00	0
33	АВЛАГА	0	25,160,000.00
33500	Бусад авлага	0	25,160,000.00
33510	Байгууллагаас авах авлага	0	25,160,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	66,350,680.08	65,960,933.20
35100	Түүхий эд материал	50,441,610.08	49,651,443.20
35110	Тусгай зориулалттай материал	50,441,610.08	49,651,443.20
35400	Хангамжийн материал	15,909,070.00	16,309,490.00
35410	Бичиг хэргийн материал	5,125,180.00	3,985,330.00
35420	Аж ахуйн материал	4,683,690.00	4,665,890.00
35430	Сэлбэг хэрэгсэл	0	2,200,000.00
35440	Түлш, шатах тослох материал	763,000.00	0
35470	Бусад хангамжийн материал	5,337,200.00	5,458,270.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	258,113,003.58	221,581,596.84
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	258,113,003.58	221,581,596.84
39200	Биет хөрөнгө	247,260,503.58	210,040,263.54
39201	Барилга, байгууламж, орон сууц	69,460,463.18	69,460,463.18
39202	Хуримтлагдсан элэгдэл	-3,796,054.34	-5,235,170.66
39203	Авто-тээврийн хэрэгсэл	79,900,000.00	79,900,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-7,768,055.54	-21,084,722.18
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	177,610,759.00	183,919,759.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-74,384,106.79	-103,525,850.99
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	11,919,680.00	8,851,446.70
39208	Хуримтлагдсан элэгдэл	-7,119,682.02	-3,433,161.64
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,000,000.00	2,000,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-562,499.91	-812,499.87
39300	Биет бус хөрөнгө	10,852,500.00	11,541,333.30
39301	Програм хангамж	1,720,000.00	1,720,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,667,500.00	-1,206,666.70
39303	Бусад биет бус хөрөнгө	10,800,000.00	11,028,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	324,529,275.66	312,702,530.04
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	324,529,275.66	312,702,530.04
51	Засгийн газрын хувь оролцоо	324,529,275.66	312,702,530.04
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	86,919,521.28	86,919,521.28
51200	Хуримтлагдсан үр дүн	233,758,637.78	221,931,892.17
51210	Өмнөх үеийн үр дүн	114,763,951.49	233,758,637.79
51220	Тайлант үеийн үр дүн	118,994,686.29	-11,826,745.62
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,851,116.60	3,851,116.59
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	324,529,275.66	312,702,530.04

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
/ төгрөгөөр /			
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	476,396,943.33	341,799,503.34
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	103,214,680.01	37,839,646.70
120	Нийтлэг татварын бус орлого	103,214,680.01	37,839,646.70
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	10,972,459.00	13,486,380.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,507,367.00	13,486,380.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	465,092.00	0
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	71,297,501.00	24,233,266.70
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	20,944,720.01	120,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	373,182,263.32	303,959,856.64
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	229,703,900.00	222,859,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	229,703,900.00	222,859,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	134,355,763.32	71,978,156.64
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	134,355,763.32	71,978,156.64
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	9,122,600.00	9,122,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	9,122,600.00	9,122,600.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	357,402,257.04	351,992,915.83
21	УРСГАЛ ЗАРДАЛ	357,402,257.04	351,992,915.83
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	301,427,038.25	302,794,376.72
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	171,819,904.12	170,672,630.92
210101	Үндсэн цалин	108,329,745.12	129,473,088.92
210102	Нэмэгдэл	47,782,959.00	29,579,407.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,153,600.00	7,449,242.00
210105	Гэрээт ажлын хөлс	11,553,600.00	4,170,893.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,740,908.86	23,963,830.92
210201	Тэтгэврийн даатгал	15,702,926.01	16,889,114.88
210202	Тэтгэмжийн даатгал	1,845,926.80	1,886,729.26
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,386,015.08	1,385,063.59
210204	Ажилгүйдлийн даатгал	341,003.27	340,265.67
210205	Эрүүл мэндийн даатгал	3,465,037.70	3,462,657.52
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,225,495.54	7,724,200.19
210301	Гэрэл, цахилгаан	809,313.54	866,712.19
210302	Түлш, халаалт	2,949,562.00	3,348,036.00
210303	Цэвэр, бохир ус	421,620.00	464,452.00
210304	Байрны түрээс	3,045,000.00	3,045,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	24,313,701.91	19,547,526.88
210401	Бичиг хэрэг	7,361,800.79	4,712,766.88
210402	Тээвэр, шатахуун	11,853,500.00	10,529,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	241,032.50	257,630.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,152,318.62	313,500.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	0	2,186,630.00
210408	Бараа материал акталсны зардал	705,050.00	1,548,000.00

Аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,502,000.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	3,502,000.00	1,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,044,000.00	639,800.00
210702	Дотоод албан томилолт	1,044,000.00	639,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,444,836.50	3,252,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	17,432,793.50	2,293,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	864,000.00	0
210803	Даатгалын үйлчилгээ	65,800.00	65,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	79,200.00	79,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	3,043.00	19,800.00
210807	Газрын төлбөр	0	10,800.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	0	783,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	52,336,191.32	75,994,187.81
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,800.00	4,012,847.50
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	52,325,391.32	71,981,340.31
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	55,975,218.79	49,198,539.11
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,237,000.00	2,004,408.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,237,000.00	2,004,408.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	53,342,850.32	13,486,380.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	53,342,850.32	13,486,380.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	897,104.46	33,634,726.45
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	897,104.46	398,399.81
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	0	33,236,326.64
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	498,264.01	73,024.66
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	498,264.01	73,024.66
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	118,994,686.29	-10,193,412.49
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0	1,633,333.13
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	0	1,633,333.13
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	118,994,686.29	-11,826,745.62

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

					/ төгрөгөөр /
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	86,919,521.28	3,851,116.60	113,732,837.45	204,503,475.33
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	1,031,114.04	1,031,114.04

**Аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	86,919,521.28	3,851,116.60	114,763,951.49	205,534,589.37
9	Тайлант үеийн үр дүн	0	0	118,994,686.29	118,994,686.29
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	86,919,521.28	3,851,116.60	233,758,637.78	324,529,275.66
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	86,919,521.28	3,851,116.60	233,758,637.78	324,529,275.66
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	86,919,521.28	3,851,116.60	233,758,637.78	324,529,275.66
19	Тайлант үеийн үр дүн	0	0	-11,826,745.62	-11,826,745.62
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	86,919,521.28	3,851,116.59	221,931,892.17	312,702,530.04

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	436,840,930.32	619,387,476.64
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	43,658,667.00	315,427,620.00
120	Нийтлэг татварын бус орлого	43,658,667.00	315,427,620.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	43,658,667.00	315,427,620.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,507,367.00	13,486,380.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	33,151,300.00	301,941,240.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	393,182,263.32	303,959,856.64
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	229,703,900.00	222,859,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	229,703,900.00	222,859,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	154,355,763.32	71,978,156.64
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	154,355,763.32	71,978,156.64
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	9,122,600.00	9,122,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	9,122,600.00	9,122,600.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	335,535,338.32	606,603,068.64
21	УРСГАЛ ЗАРДАЛ	335,535,338.32	606,603,068.64
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	278,492,119.53	557,404,529.53
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	171,821,907.80	170,672,630.92
210101	Үндсэн цалин	108,331,748.80	129,473,088.92
210102	Нэмэгдэл	47,782,959.00	29,579,407.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,153,600.00	7,449,242.00
210104	Урамшуулал	0	0
210105	Гэрээт ажлын хөлс	11,553,600.00	4,170,893.00

Аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,740,905.19	23,963,830.92
210201	Тэтгэврийн даатгал	15,697,382.32	17,032,308.79
210202	Тэтгэмжийн даатгал	1,836,368.91	1,817,774.20
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,390,041.49	1,377,947.93
210204	Ажилгүйдлийн даатгал	342,011.42	339,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,475,101.05	3,396,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,225,495.54	7,724,200.19
210301	Гэрэл, цахилгаан	809,313.54	866,712.19
210302	Түлш, халаалт	2,949,562.00	3,348,036.00
210303	Цэвэр, бохир ус	421,620.00	464,452.00
210304	Байрны түрээс	3,045,000.00	3,045,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,679,990.00	14,075,960.00
210401	Бичиг хэрэг	1,769,500.00	2,600,500.00
210402	Тээвэр, шатахуун	10,363,000.00	9,766,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	222,090.00	257,630.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,325,400.00	1,451,830.00
2105	Нормативт зардал	396,000.00	0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	396,000.00	0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	26,473,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0	25,160,000.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	1,313,500.00
2107	Томилолт, зочны зардал	1,044,000.00	639,800.00
210702	Дотоод албан томилолт	1,044,000.00	639,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	59,883,821.00	304,409,840.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	26,185,570.00	2,293,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	864,000.00	0
210803	Даатгалын үйлчилгээ	65,800.00	65,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	79,200.00	79,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	3,043.00	19,800.00
210807	Газрын төлбөр	0	10,800.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	32,686,208.00	301,941,240.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	700,000.00	9,444,767.50
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	700,000.00	9,444,767.50
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	57,043,218.79	49,198,539.11
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,305,000.00	2,004,408.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,305,000.00	2,004,408.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	53,342,850.32	46,722,706.64
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	53,342,850.32	46,722,706.64
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	897,104.46	398,399.81
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	897,104.46	398,399.81
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	498,264.01	73,024.66
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	498,264.01	73,024.66
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	101,305,592.00	12,784,408.00

Аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	101,240,000.00	12,850,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	101,240,000.00	12,850,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	101,240,000.00	12,850,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	101,240,000.00	12,850,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	101,240,000.00	-12,850,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	65,592.00	-65,592.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	65,592.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	65,592.00	0

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /				
Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	231,981,700.00	231,510,275.53	471,424.47
21	УРСГАЛ ЗАРДАЛ	231,981,700.00	231,510,275.53	471,424.47
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	229,976,500.00	229,505,867.53	470,632.47
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	170,673,500.00	170,672,630.92	869.08
210101	Үндсэн цалин	104,436,900.00	129,473,088.92	-25,036,188.92
210102	Нэмэгдэл	49,107,800.00	29,579,407.00	19,528,393.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,110,600.00	7,449,242.00	-4,338,642.00
210105	Гэрээт ажлын хөлс	14,018,200.00	4,170,893.00	9,847,307.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,024,300.00	23,963,830.92	60,469.08
210201	Тэтгэврийн даатгал	17,231,900.00	17,032,308.79	199,591.21
210202	Тэтгэмжийн даатгал	1,698,100.00	1,817,774.20	-119,674.20
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,358,500.00	1,377,947.93	-19,447.93
210204	Ажилгүйдлийн даатгал	339,600.00	339,600.00	0.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,396,200.00	3,396,200.00	0.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,122,600.00	7,724,200.19	398,399.81
210301	Гэрэл, цахилгаан	1,348,400.00	866,712.19	481,687.81
210302	Түлш, халаалт	3,121,600.00	3,348,036.00	-226,436.00
210303	Цэвэр, бохир ус	530,800.00	464,452.00	66,348.00
210304	Байрны түрээс	3,121,800.00	3,045,000.00	76,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,272,800.00	11,272,630.00	170.00
210401	Бичиг хэрэг	1,594,500.00	1,594,500.00	0.00
210402	Тээвэр, шатахуун	8,374,100.00	8,374,000.00	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	222,300.00	222,300.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,081,900.00	1,081,830.00	70.00

**Аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	1,000,000.00	0.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	1,000,000.00	0.00
2107	Томилолт, зочны зардал	455,800.00	447,800.00	8,000.00
210702	Дотоод албан томилолт	455,800.00	447,800.00	8,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	175,600.00	175,600.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	65,800.00	65,800.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	79,200.00	79,200.00	0.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	19,800.00	19,800.00	0.00
210807	Газрын төлбөр	10,800.00	10,800.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,251,900.00	14,249,175.50	2,724.50
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,251,900.00	14,249,175.50	2,724.50
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,005,200.00	2,004,408.00	792.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,005,200.00	2,004,408.00	792.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,005,200.00	2,004,408.00	792.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	231,981,700.00	231,510,275.53	471,424.47
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	222,859,100.00	222,786,075.34	73,024.66
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	9,122,600.00	8,724,200.19	398,399.81
320001	Орон нутгийн төсвөөс	9,122,600.00	8,724,200.19	398,399.81

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/ төгрөгөөр / Зөрүү
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		38,741,830.00	(38,741,830.00)
3	УРСГАЛ ЗАРДАЛ		38,741,830.00	(38,741,830.00)
4	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		38,741,830.00	(38,741,830.00)
5	Хангамжийн бараа материалын зардал		2,803,330.00	(2,803,330.00)
6	Бичиг хэрэг		1,006,000.00	(1,006,000.00)
7	Тээвэр шатахуун		1,392,000.00	(1,392,000.00)
8	Шуудан холбоо, интернэтийн төлбөр		35,330.00	(35,330.00)
9	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс		370,000.00	(370,000.00)
10	Эд хогшил, урсгал засварын зардал		32,773,500.00	(32,773,500.00)
11	Багаж, техник, хэрэгсэл		32,460,000.00	(32,460,000.00)
12	Урсгал засвар		313,500.00	(313,500.00)
13	Томилолт, зочны зардал		192,000.00	(192,000.00)
14	Дотоод албан томилолт		192,000.00	(192,000.00)

Аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

15	Бусдаар, гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,293,000.00	(2,293,000.00)
16	Бусдаар, гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,293,000.00	(2,293,000.00)
17	Бараа үйлчилгээний бусад зардал	680,000.00	(680,000.00)
18	Бараа үйлчилгээний бусад зардал	680,000.00	(680,000.00)
19	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	71,978,156.64	(71,978,156.,64)
20	Нэмэлт санхүүжилтийн орлого	71,978,156.64	(71,978,156.,64)
21	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	71,978,156.64	(71,978,156.,64)

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Говьсүмбэр аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд зөвлөмж өгөгдөөгүй

Аудитыг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Батсайхан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Наранбаяр, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Сарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01/25 дугаар албан бичгээр хуульд заасан хугацаанд ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Тайлант онд аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар нь дараах зорилтыг дэвшүүлсэн байна. Үүнд:

- Газар эзэмшигч, өмчлөгч, ашиглагч суурь судалгааг үнэн бодит гаргах, газар эзэмшигч, өмчлөгч, ашиглагчийн мэдээллийг цахим хэлбэрт оруулах, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудыг газрын харилцааны чиглэлээр бодит мэдээллээр хангаж, мэргэжлийн чиглэлээр эрх зүйн туслалцаа үзүүлж байх
- Аймгийн ерөнхий төлөвлөгөөний дагуу барилгажилт тохижилтын ажлыг мөрдүүлэх, барилгын материалын лабораторийн үйл ажиллагааг тогтмолжуулж, орон нутагт нийлүүлж байгаа барилгын материалын лабораторийн үйл ажиллагааг тогтмолжуулж, орон нутагт нийлүүлж байгаа барилгын материалын чанар, барилгын гүйцэтгэлийн ажилд техник хяналтыг мэргэжлийн өндөр түвшинд тавих
- Орон сууц, нийтийн аж ахуйн салбарыг хөгжүүлэх бодлогын хэрэгжилтийг хангуулах
- Нутаг дэвсгэр дээрх газар, үл хөдлөх хөрөнгийг кадастрын бүртгэлээр баталгаажуулах, мэдээллийн сан, хувийн хэрэг, газрын бирж, үнийн мэдээ, үнэлгээ, төлбөр, татварын тогтолцоог сайжруулж, хэрэглэгчийг баталгаат мэдээллээр хангах

Байгууллагын зорилго, зорилтыг ханган ажиллахаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан үр дүнгийн гэрээнд нийт 44 зорилт, 88 арга хэмжээг төлөвлөн хэрэгжилтийг жилийн эцсийн байдлаар 89.3%-тай ханган ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна..

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар, түүний дотор дотоод аудитор нь тайлант онд тус газрын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгээгүй байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас тус газрын 2019-2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд Сангийн сайдын баталсан удирдамжийн дагуу хяналт шалгалт хийж, 45,557.7 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, 4,522.3 мянган төгрөгийн төлбөрийн 6 акт тогтоож, 1,668.4 мянган төгрөгийн 3 албан шаардлага өгч, 39,367.0 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгснийг гүйцэтгэлээр бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн тайлангийн үр дүнгийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн тайлангийн үр дүнгийн зардлын 339,331.7 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 3,393.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 2,714.6 мянган төгрөгөөр тогтоосон

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 11,826.7 мянган төгрөгөөр буюу 3.6 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын оролцоо дансад материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	65.6		-65.6
Авлага	0.0	25,160.0	25,160.0

Аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Урьдчилгаа			0.0
Бараа материал	66,350.7	65,960.9	-389.7
Үндсэн хөрөнгө	258,113.0	221,581.6	-36,531.4
<b>Нийт хөрөнгө</b>	<b>324,529.3</b>	<b>312,702.5</b>	<b>-11,826.7</b>
Өр төлбөр			0.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	324,529.3	312,702.5	-11,826.7
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>324,529.3</b>	<b>312,702.5</b>	<b>-11,826.7</b>

Мөнгөн хөрөнгийн данс 65.6 мянган төгрөгөөр буурсан нь ахмадын сангийн эхний үлдэгдлийг тайлант хугацаанд зарцуулсан байна.

Авлага дансны үлдэгдэл 25,160.0 мянган төгрөгөөр өссөн нь тайланд хугацаанд худалдан авсан материалыг хил хаагдсанаас шалтгаалан хүлээн аваагүй бөгөөд бэлтгэн нийлүүлэгч компанитай байгуулсан гэрээний хугацааг сунгасантай холбоотой байна.

Авлагын үлдэгдэл нь 2 компаниас авах бараа материалын авлага 25,160.0 мянган төгрөг байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 65,960.9 мянган төгрөг болж 389.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд өмнөх оны үлдэгдлийг зарцуулсан нь нөлөөлжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 66,350.7 мянган төгрөг байснаас тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 19,563.7 мянга, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газраас 120.0 мянган төгрөгийн бараа материал үнэ төлбөргүй хүлээн авч нийт 19,683.7 мянган төгрөгөөр нэмэгдэж, зарцуулсан 18,525.5 мянга, газрын даргын 2021.07.30-ны өдрийн А/26 тоот тушаалаар 1,548.0 мянган төгрөгийн бараа материалыг акталж, нийт 20,073.5 мянган төгрөгөөр хасагдаж, 65,960.9 мянган төгрөгийг үлдэгдлээр тайлагнасан байна.

Бараа материалын дансны үлдэгдэлд тусгай зориулалтын материал 49,651.4 мянга, бичиг хэргийн материал 3,985.4 мянга, аж ахуйн материалын 4,665.9 мянга, сэлбэг хэрэгсэл 2,200.0 мянга, бусад хангамжийн материал 5,458.2 мянган төгрөг тус тус байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 356,879.7 мянган төгрөг болж 3,468.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд анхны өртгөө элэгдлээрээ нөхсөн үндсэн хөрөнгийг дахин үнэлсэн, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал болон Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газраас үнэ төлбөргүй хөрөнгө хүлээн авсан зэргээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 353,410.9 мянган төгрөг байснаас тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 12,850.0 мянга, үнэ төлбөргүй хүлээн авсан 24,233.3 мянга, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газраас 847.3 мянга, газрын даргын 2021.06.23-ны өдрийн А/23 тоот тушаалаар байгууллагын граашийн газар 228.0 мянга, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021.01.26-ны өдрийн 17 дугаар тогтоолоор 9 нэр, төрлийн 12 ширхэг хөрөнгийг 21,780.0 мянган төгрөгөөр дахин үнэлж орлого авсан, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021.12.29-ний өдрийн А/217 дугаар тогтоолоор байршил тогтоогч төхөөрөмж 1,378.0 мянга, нийт 37,083.3 мянган төгрөгөөр нэмэгдэж, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2021.01.09-ний А-1/106 дугаар тогтоолоор 9,039.6 мянга, 2021.01.26-ны өдрийн 17 дугаар тогтоолоор 24,574.9 мянга, нийт 33,614.5 мянган төгрөгийн хөрөнгийг данснаас акталж 356,879.7 мянган төгрөгийг үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Биет бус хөрөнгө нь тайлант онд 11,541.3 мянган төгрөг болж 688.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд санхүүгийн программыг 880.0 мянган төгрөгөөр дахин үнэлсэн, граашийн газрыг 228.0 мянган төгрөгөөр үнэлж бүртгэсэн зэрэг нийт 1,108.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, тайлант үеийн элэгдэл 419.0 мянган төгрөгөөр хасагдсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 312,702.5 мянган төгрөг болж 11,826.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацааны үр дүнгээр буурсан байна.

Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 63,299.9 мянган төгрөгөөр буюу 15.6 хувиар буурсан ба өмнөх оны үзүүлэлтээс үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө, бараа материалын орлого 3,408.6 мянга, үндсэн үйл ажиллагааны орлого 2,513.9 мянга нийт 5,922.5 мянган төгрөгөөр нэмэгдэж, нийт / 69,222.4 мянган төгрөгөөр санхүүжилтийн орлого 6,844.8 мянга, нэмэлт санхүүжилтийн орлого 62,377.6/ мянга/ буурч материаллаг өөрчлөлт гарсан байна.

Аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 63,299.9 мянган төгрөгөөр буюу 15.6 хувиар буурсан ба өмнөх оны үзүүлэлтээс үнэ төлбөргүй үндсэн хөрөнгө, бараа материалын орлого 3,408.6 мянга, үндсэн үйл ажиллагааны орлого 2,513.9 мянга нийт 5,922.5 мянган төгрөгөөр нэмэгдэж, / нийт 69,222.4 мянган төгрөгөөр санхүүжилтийн орлого 6,844.8 мянга, нэмэлт санхүүжилтийн орлого 62,377.6 мянга/ буурч материаллаг өөрчлөлт гарсан байна.

Энэ нь тайланд онд анх батлагдсан төсвөөс төсвийн тодотголоор 4,856.0 мянган төгрөгөөр хасаж баталсан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг дахин үнэлсэн, тайлант онд захиалагчийн хяналт тавих хөрөнгө оруулалтын ажил бага батлагдсан зэрэг нь нөлөөлжээ.

Нийт зардал өмнөх оноос 12,591.2 мянган төгрөгөөр буюу 3.7 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардал нь үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардал бөгөөд энэ нь тайлант онд хөрөнгийг дахин үнэлсэнтэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайланд өмнөх оны үр дүн рүү хаасан нягтлан бодох бүртгэлийн залруулга хийгдээгүй байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 383,984.2 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 383,984.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн ба төсвийн төслийг 147,146.5 мянган төгрөгөөр бууруулж, 236,837.7 мянган төгрөгөөр баталсан байна.

Анх 236,837.7 мянган төгрөгийн төсөв батлагдсан боловч төсвийн тодотголоор байр Нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 1,100.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, хангамжийн бараа материалын зардлыг 243.5 мянга, нормын хувцас зөөлөн эдлэлийн зардлыг 396.0 мянга, дотоод албан томилолтын зардлыг 2,124.0 мянга, бараа үйлчилгээний бусад зардлыг 2,124.0 мянга, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлыг 300.0 мянга, нийт 5,956.0 мянган төгрөгөөр тус тус бууруулж, 231,981.7 мянган төгрөгөөр төсөв баталсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх “71504-Газрын зураглал, кадастр” 1 хөтөлбөрийн хүрээнд 80801-үндсэн үйл ажиллагааны арга хэмжээг санхүүжүүлэхээр 215,724.6 мянга, 80802-ажил олгогчийн тэтгэмж урамшуулал арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,005.2 мянга, 82404-барилгын техник хяналт арга хэмжээг санхүүжүүлэхээр 14,251.9 мянга, нийт 231,981.7 мянган төгрөгийн төсөв баталснаас

222,859.1 мянган төгрөгийг улсын төсвөөс, 9,122.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 222,859.1 мянга, орон нутгийн төсвөөс 9,122.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, 231,510.3 мянган төгрөгийг урсгал үйл ажиллагаанд зарцуулж, 73.0 мянган төгрөгийг улсын төсөвт, 398.4 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 231,510.3 мянган төгрөг буюу 99.8 хувьтай байгаа нь цалин, НДШ-ийн зардлыг 61.3 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 398.4 мянга, дотоод албан томилолтын зардлыг 8.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрийг 3.7 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Санхүүгийн үр дүнгийн тайланд улсын төсвөөс санхүүжилт 222,859.1 мянга, орон нутгийн төсвөөс санхүүжилт 9,122.6 мянга, нэмэлт санхүүжилтийн орлого 71,978.1 мянга, үндсэн үйл ажиллагааны орлого 13,486.3 мянга, үнэ төлбөргүй үндсэн хөрөнгө бараа материалын орлого 24,353.4 мянга, нийт 341,799.5 мянган төгрөгийн орлого тайлагнасан байна.

Мөнгөн гүйлгээний тайланд улсын төсвөөс санхүүжилт 222,859.1 мянга, орон нутгийн төсвөөс санхүүжилт 9,122.6 мянга, нэмэлт санхүүжилтийн орлого 71,978.1 мянга, үндсэн үйл ажиллагааны орлого 13,486.3 мянга, дуудлага худалдааны дэнчингийн орлого 301,941.3 мянга, нийт 619,387.4 мянган төгрөгийн орлого тайлагнасан байна.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд хөрөнгө оруулалтын 23 ажилд хяналт тавьж 71,978.1 мянган төгрөгийн хяналтын орлого төвлөрүүлснээс бичиг хэргийн зардалд 1,006.0 мянга, тээвэр шатахууны зардалд 1,392.0 мянга, шуудан холбооны зардалд 35.3 мянга, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлсийн зардалд 370.0 мянга, багаж техник хэрэгслийн зардалд 32,460.0 мянга, урсгал засварын зардалд 313.5 мянга, дотоод албан томилолтын зардалд 192.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрт 2,293.0 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 680.0 мянга, нийт 38,741.8 мянган төгрөгийг зарцуулж, 33,236.3 мянган төгрөгийн улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Аудитаар Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/108, А/111 дүгээр тушаалаар батлагдсан ерөнхий чиглэлд тусгагдсан асуудлыг онцлон үзсэн боловч зөрчил илрээгүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

Аймгийн газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын даргын 2021 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын 2021.07.08-ны өдрийн А/151 дүгээр тушаалаар “В” буюу сайн гэж үнэлж нэг сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээгээр мөнгөн урамшуулал олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4-т “төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх”, “16.5.5“батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2 дугаар зүйлийн 2.2-т “Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан

тушаалын сарын үндсэн цалингийн 40 хувиас хэтрэхгүй байна” гэснийг тус тус зөрчсөн тул удирдах газарт нь уламжлах шаардлагатай гэж үзлээ.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 8 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Говьсүмбэр аймгийн “Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар” нь 2021 онд нийт 193.310.9 мянган төгрөгийн 19 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахыг бүрэн мэдээлсэн байна

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийг арилгах 1 албан шаардлага, байгууллагын үйл ажиллагаанд нийцүүлэн дотоод хяналтын журам боловсруулж, хэрэгжүүлэх, татварын цахим бүртгэлийн системээр зарцуулалтыг хянаж байх зөвлөмж өгснийг хэрэгжүүлж ажилласан бөгөөд хэрэгжилт 100.0%-тай байна.

Хүснэгт 2 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1		1		-	-	-
Зөвлөмж	1		1		-	-	-
<b>Нийт дүн</b>	<b>2</b>		<b>2</b>		-	-	-

#### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын үйл ажиллагаанд анхаарал татахуйц асуудал байхгүй байна

#### **4. Аудитын илрүүлэлт**

---

Аудитаар нийт 7,498.8 мянган төгрөгийн 4 алдаа, зөрчлийг завсрын аудитаар залруулах зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

##### **4.1 Залруулсан алдаа**

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой илэрсэн 7,498.8 мянган төгрөгийн дараах 4 алдааг завсрын аудитаар залруулав. Үүнд:

1. Төсвийн гүйцэтгэлийн тайланд батлагдсан төсвийг 2,735.8 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан
2. 2021 оны эхний хагас жилд санхүүгийн тайланд 3,071.5 мянган төгрөгийн НДШ-ийн өглөг үүсгэсэн
3. 2021 оны эхний хагас жилийн хөрөнгийн тооллогын тайланг баталгаажуулаагүй, бичиг хэргийн материалыг тооллогын дүнд 41.5 мянган төгрөгөөр дутуу тусгасан
4. 2021 оны эхний хагас жилд барилга байгууламж, бусад үндсэн хөрөнгө, автомашины нярвын тайланг гаргаагүй 1,650.0 мянга

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/ мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар	4	7,498.8	4	7,498.8	0	0	0	0	1	0